


БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Я.АМАРЖАРГАЛ



НИЙЛҮҮЛЭГЧ

МОНГОЛ ЭМ ИМПЭКС КОНЦЕРН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БОЛОРМАА



ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-2019)-ЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН
ХЭРЭГСЭЛ, НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 75

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Монгол эм импэкс концерн ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь эм, Шинэ коронавируст халдвар (COVID-19)-ын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх) 318 208 000 (гурван зуун арван найман сая хоёр зуун найман мянган) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

арааны нэр, төрөл	Багцын дугаар	Үйлдвэрлэгчийн нэр, Үйлдвэрлэсэн улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
идол 100 мг	1	Фармстандарт- Лексредства, ОХУ	капсул	30 000	1287	38 610 000

ирин 200	2	“Озон” ОХУ	капсул	12 000	990	11 880 000
ферон 1000	4	Биомед им. Мечникова, ОХУ, Changchun Heber Biological Technology, БНХАУ	тарилгын уусмал	3 000	14 850	44 550 000
ин л-5мл	18	Ротекс медика, Герман	тарилгын уусмал	1 000	4 730	4 730 000
инефрин -2мл	20	Неон Лабораториес	тарилгын уусмал	7 000	30 800	215 600 000
фрин -1мл	21	Москва Эндокринный завод	тарилгын уусмал	3 000	946	2 838 000
						318 208 000

- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг гурван зуун арван найман сая хоёр зуун найман мянган төгрөгийг Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь 6 нэр төрлийн барааг 2020 оны 03 дугаар сарын 17-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн төхиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телеко, цахилгаан болон факсаар харилцана.

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, еерчлэлт.



Хүснэгт 1. Санхүүжилтийн хуваарь


Д/Д	Барааны нэр, төрөл	Багцийн дугаар	Урьдчилгаа /төгрөг/	Гүйцэтгэл /төгрөг/
1	Арбидол 100 мг	1	19,305,000.00	19,305,000.00
2	Рибавирин 200 мг	2	5,940,000.00	5,940,000.00
3	Интерферон альфа 1000 ОУН	4	22,275,000.00	22,275,000.00
4	Допамин 40мг/мл-5мл	18	2,365,000.00	2,365,000.00
5	Норэпинефрин 2мг/мл-2мл	20	107,800,000.00	107,800,000.00
6	Эпинефрин 1мг/мл-1мл	21	1,419,000.00	1,419,000.00

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
- (б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
- (в) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (г) “Хүчинтэй болох хугацаа” Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.
- (д) “Ашиглагч” Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.
- (е) “ГЕН” Гэрээний Ерөнхий Нөхцөл.
- (ж) “Бараа” Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм,эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.
- (з) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
- (и) “Бүртгэлийн гэрчилгээ” хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.



ХХ КОМПАНИ